

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШУА	Шинжлэх ухааны академи



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ФИЗИК, ТЕХНОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ  
П.АЛТАНЦОГ ТАНАА

2020.03.06 № 06/737  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал П.Алтанцог Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн бараа материалын тооллогын бүртгэлийг баталгаажуулж байх, эд хөрөнгийн ашиглалтын карт, анхан шатны бүртгэлийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 8-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Физик, технологийн хүрээлэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Физик, технологийн хүрээлэн нь зорилгоо “Шинжлэх ухаан технологи, инновацийг хөгжүүлэх, улс орны нийгэм, эдийн засаг, оюуны хөгжлийн тулгамдсан асуудлыг орчин үеийн шинжлэх ухааны түвшинд судлан боловсруулах, шинэ мэдлэг, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох” гэж тодорхойлжээ.

Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан Физик, технологийн хүрээлэнгийн дүрмэнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Физик, технологийн салбарын суурь ба хавсарга судалгааны бодлого, чиглэлийг тодорхойлоход манлайлан оролцох;
- Холбогдох салбарын суурь судалгаа явуулж, олон улсын, Засгийн газрын болон бусад төслүүдийг гүйцэтгэх замаар судалгаа-боловсруулалтын ажлын үр дүнг амьдрал практикт нэвтрүүлэх;
- Эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох залуу халааг бэлтгэх замаар хамтарч ажиллах;
- Олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг патентлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах үйл ажиллагаа явуулах;
- Эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар зохион байгуулах, ном бүтээл хэвлэх;
- Зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран туршилт-үйлдвэрлэлийн түшиц цех, нэгж байгуулах;
- Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үндэслэн төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгжид санал, зөвлөмж хүргүүлэх, үйл ажиллагааныхаа үр дүнг тогтоосон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнахаар тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт гараагүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Физик, технологийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Acolous программ хангамж ашигладаг байна.

Физик, технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Физик, технологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,021,363.0 мянган төгрөгөөс тооцон 20,213.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 538,028.4 мянган төгрөгөөр буюу 45.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	680.0	0.0	(680.0)
Бараа материал	190,590.9	199,436.1	8,845.2
Үндсэн хөрөнгө	7,093,863.7	7,291,279.4	197,415.7
Хуримтлагдсан элэгдэл	(2,171,158.6)	(2,228,268.4)	(57,109.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,113,976.0</b>	<b>5,262,447.1</b>	<b>148,471.1</b>
Өр төлбөр	680.0	0.0	(680.0)
Өмч	2,804,884.1	2,804,884.1	0.0
Хуримтлагдсан үр дүн	(1,591,516.1)	(1,442,365.0)	149,151.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,899,928.0	3,899,928.0	0.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,113,976.0</b>	<b>5,262,447.1</b>	<b>148,471.1</b>

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, өр төлбөр, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 29,955.0 мянган төгрөгийн тусгай зориулалттай материал буюу химийн урвалж бодис худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө 197,415.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд эрдэм шинжилгээний зардлаас 62,067.2 мянга, урсгал санхүүжилтээр 34,999.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, Шилний лабораториос 155,439.0 мянга, БСШУСЯ-аас 263,101.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авснаас шалтгаалсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 7 дугаар сарын А-2/2247 дугаар зөвшөөрлөөр 41 нэр төрлийн 64,996.1 мянган төгрөгийн, 2019 оны 299 дүгээр

тогтоолоор 96 нэр төрлийн 82,897.1 мянган төгрөгийн нийт 147,893.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу Математик, тоон технологийн хүрээлэнд 123,882.3 мянган төгрөгийн машин тоног, төхөөрөмж, 41,823.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,561.5 мянган төгрөгийн ном нийт 170,267.5 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Физик, технологийн хүрээлэн тайлант онд улсын төсвөөс 1,493,597.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 18,492.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 1,512,083.5 мянган төгрөг зарцуулж, 6.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Шинжлэх ухаан технологийн сангаас 227,224.0 мянга, Дэлхийн шинжлэх ухааны академиас 12,642.4 мянга, үйл ажиллагааны давсан орлого 17.8 мянга, нийт 239,884.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 239,866.3 мянган төгрөгийг зарцуулж, 17.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж, нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 17,100.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус хүрээлэнгийн тусгай зориулалттай бараа материалын зарцуулалтыг дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Физик, технологийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тухай бүрт нь байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохих ёсоор баталгаажуулаагүй, 1,800.0 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас, шатахууны зардлыг баримтжуулаагүй, 96,532.9 мянган төгрөгийн ибаримтгүй худалдан авалт хийсэн, 463.9 мянган төгрөгийн татварын авлагыг тайланд тусгаагүй зөрчлийг засах 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.



Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа*

##### *1.1. Илрүүлэлт:*

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж тайлант оны үндсэн хөрөнгийн тооллогыг зохих ёсоор хийж, баталгаажуулсан боловч бараа материалын тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д “тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг ... үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.4-т “... тооллогын бүртгэлийг баталгаажуулж”

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага ... хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### *1.2. Эрсдэл:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх, бараа материал дутагдах;

##### *1.3. Өгсөн зөвлөмж:*

Бараа материалын тооллогын бүртгэлийг зохих ёсоор баталгаажуулж байх

##### *1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

#### *2. Балансын данстай холбоотой асуудал*

##### *2.1. Илрүүлэлт:*

Зарим ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа нийт 17,100.6 мянган төгрөгийн эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд код, чанар, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тусгаагүй, эзэмшигчээр гарын үсэг зуруулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан журманд “анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” заасантай нийцэхгүй байна.

## 2.2. Эрсдэл:

Байгууллагын хөрөнгө шамшигдах, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан журам хэрэгжээгүй байх;

## 2.3. Өгсөн зөвлөмж:

Ажилтнуудын эд хөрөнгийн ашиглалтын картыг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын дагуу бүрэн хөтөлж, баталгаажуулах

## 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>191,270,899.93</u></b>	<b><u>199,436,126.87</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	680,000.00	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	680,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	190,590,899.93	199,436,126.87
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	165,140,651.93	174,494,676.87
35110	Тусгай зориулалттай материал	165,140,651.93	174,494,676.87
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,450,248.00	24,941,450.00
35410	Бичиг хэргийн материал	15,517,749.00	15,426,603.00
35420	Аж ахуйн материал	9,932,499.00	9,514,847.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,922,705,129.51</u></b>	<b><u>5,063,010,957.05</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,922,705,129.51	5,063,010,957.05
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,638,959,189.51	4,779,265,017.05
39201	Барилга, байгууламж, орон	4,212,379,176.30	4,212,379,176.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,800,000.00)	(165,967,573.8)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,495,833.25	21,495,833.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,657,430.52)	(8,240,069.4)
39205	Машин тоног төхөөрөмж	2,400,618,213.44	2,381,688,987.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,030,836,790.53)	(1,944,161,852.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	151,982,012.27	372,888,433.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(129,262,499.55)	(105,297,079.5)
39213	Түүх соёл, музейн дурсгалт	203,910.00	203,910.00
39217	Ном	18,836,764.85	14,275,252.90
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	283,745,940.00	283,745,940.00
39301	Програм хангамж	4,601,840.00	4,601,840.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,601,840.0)	(4,601,840.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	283,745,940.00	283,745,940.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>5,113,976,029.44</u></b>	<b><u>5,262,447,083.44</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>680,000.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	680,000.00	0.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	680,000.00	0.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	680,000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	680,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>5,113,296,029.44</u></b>	<b><u>5,262,447,083.92</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,804,884,082.53	2,804,884,082.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,804,884,082.53	2,804,884,082.53
51101	Өмч: - төрийн	2,804,884,082.53	2,804,884,082.53
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(1,591,516,076.84)	(1,442,365,022.36)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,591,516,076.84)	(1,591,516,076.84)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	149,151,054.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,899,928,023.75	3,899,928,023.75
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>5,113,976,029.44</u></b>	<b><u>5,262,447,083.92</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,632,603,842.86</b>	<b>2,170,514,054.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>41,641,548.86</b>	<b>437,050,644.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	41,641,548.86	437,050,644.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,641,548.86	437,050,644.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,500,006.00	18,510,644.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,141,542.86	418,540,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,590,962,294.00</b>	<b>1,733,463,410.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,355,866,000.00	1,493,597,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,355,866,000.00	1,493,597,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	235,096,294.00	239,866,410.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,304,294.00	12,642,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	211,792,000.00	227,224,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,741,851,516.12</b>	<b>1,983,527,821.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,738,812,584.12</b>	<b>1,979,409,254.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,738,812,584.12	1,979,409,254.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,030,230,800.00	1,106,600,900.00
210101	Үндсэн цалин	960,032,340.00	978,100,700.00
210102	Нэмэгдэл	64,340,101.00	118,607,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,858,359.00	9,892,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	121,062,574.00	137,041,862.00
210201	Тэтгэврийн даатгал	85,585,823.00	85,670,962.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,248,401.00	12,842,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,332,560.00	10,274,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,482,825.00	2,568,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,412,965.00	25,685,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,608,200.00	53,024,048.93
210301	Гэрэл, цахилгаан	27,313,000.00	24,873,066.94
210302	Түлш, халаалт	29,871,753.25	25,539,669.37
210303	Цэвэр, бохир ус	2,423,446.75	2,611,312.62
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,727,374.04	33,998,391.61
210401	Бичиг хэрэг	2,678,598.04	11,056,270.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,848,452.35	1,862,668.61
210404	Ном, хэвлэл	1,799,200.00	731,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,221,123.65	18,017,653.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,009,360.00	25,411,190.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	180,000.00
210604	Урсгал засвар	20,009,360.00	25,231,190.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,320,000.00	2,000,000.00
210701	Гадаад албан томилолт	5,300,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4,020,000.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>302,089,580.92</b>	<b>279,653,258.91</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299,109,580.92	275,929,421.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	1,743,837.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	183,764,695.16	341,679,603.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,985,400.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	181,779,295.16	341,679,603.46
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,600,000.00	4,094,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	4,094,300.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,438,932.00	24,266.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,438,932.00	6,340.46
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		17,926.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(109,247,673.3)</u></b>	<b><u>186,986,232.48</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	0.00	<b>37,835,178.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	33,591,008.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	4,244,170.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	0.00	(37,835,178.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(109,247,673.3)</u></b>	<b><u>149,151,054.48</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,610,142,300.00</u></b>	<b><u>1,751,974,054.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>19,180,006.00</b>	<b>18,510,644.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	19,180,006.00	18,510,644.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	19,180,006.00	18,510,644.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,500,006.00	18,510,644.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	680,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,590,962,294.00</b>	<b>1,733,463,410.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,355,866,000.00	1,493,597,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,355,866,000.00	1,493,597,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	235,096,294.00	239,866,410.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,304,294.00	12,642,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	211,792,000.00	227,224,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,569,983,610.00</u></b>	<b><u>1,654,937,615.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,569,983,610.00</b>	<b>1,650,819,048.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,566,264,678.00</b>	<b>1,650,819,048.39</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,030,230,800.00	1,106,600,900.00
210101	Үндсэн цалин	960,032,340.00	978,100,700.00
210102	Нэмэгдэл	64,340,101.00	118,607,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,858,359.00	9,892,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	121,062,574.00	137,041,862.00
210201	Тэтгэврийн даатгал	85,585,823.00	85,670,962.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,248,401.00	12,842,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,332,560.00	10,274,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,482,825.00	2,568,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,412,965.00	25,685,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,608,200.00	53,024,048.93
210301	Гэрэл, цахилгаан	27,313,000.00	24,873,066.94
210302	Түлш, халаалт	29,871,753.25	25,539,669.37
210303	Цэвэр, бохир ус	2,423,446.75	2,611,312.62
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,285,000.00	18,273,977.61
210401	Бичиг хэрэг	3,270,000.00	2,744,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,848,452.35	1,862,668.61
210404	Ном, хэвлэл	1,799,200.00	731,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,187,347.65	10,604,809.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,747,000.00	32,215,980.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	215,980.00
210604	Урсгал засвар	21,747,000.00	32,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,320,000.00	2,000,000.00
210701	Гадаад албан томилолт	5,300,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4,020,000.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	306,025,704.00	301,662,279.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	303,045,704.00	297,938,442.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	1,743,837.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,985,400.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,985,400.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,718,932.00</b>	<b>4,118,566.61</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,600,000.00	4,094,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	4,094,300.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,118,932.00	24,266.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,118,932.00	6,340.46
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		17,926.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>40,158,690.00</u></b>	<b><u>97,036,439.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>40,158,690.00</b>	<b>97,036,439.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,158,690.00</b>	<b>97,036,439.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	40,158,690.00	97,036,439.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,158,690.00	97,036,439.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(40,158,690.00)</u></b>	<b><u>(97,036,439.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	0.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	0.00



#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,521,138,142.53</b>	<b>236,978,532.98</b>	<b>(1,482,268,403.6)</b>	<b>1,275,848,271.93</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	283,745,940.00	3,662,949,490.77	0.00	3,946,695,430.77
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(109,247,673.3)	(109,247,673.3)
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,804,884,082.53</b>	<b>3,899,928,023.75</b>	<b>(1,591,516,076.8)</b>	<b>5,113,296,029.44</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	149,151,054.48	149,151,054.48
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,804,884,082.53</b>	<b>3,899,928,023.75</b>	<b>(1,442,365,022.4)</b>	<b>5,262,447,083.92</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,512,097,000.00</b>	<b>1,512,083,475.54</b>	<b>13,524.46</b>	100.0
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,512,097,000.00	1,512,083,475.54	13,524.46	100.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,507,997,000.00</b>	<b>1,507,989,175.54</b>	<b>7,824.46</b>	100.0
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,106,600,900.00	1,106,600,900.00	0.00	100.0
Үндсэн цалин	978,100,700.00	978,100,700.00	0.00	100.0
Нэмэгдэл	118,607,900.00	118,607,900.00	0.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	9,892,300.00	9,892,300.00	0.00	100.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>137,042,100.00</b>	<b>137,041,862.00</b>	<b>238.00</b>	100.0
Тэтгэврийн даатгал	85,671,200.00	85,670,962.00	238.00	100.0
Тэтгэмжийн даатгал	12,842,700.00	12,842,700.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	10,274,200.00	10,274,200.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,568,500.00	2,568,500.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	25,685,500.00	25,685,500.00	0.00	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>53,030,000.00</b>	<b>53,024,048.93</b>	<b>5,951.07</b>	100.0
Гэрэл, цахилгаан	29,450,000.00	24,873,066.94	4,576,933.06	84.5
Түлш, халаалт	21,180,000.00	25,539,669.37	(4,359,669.37)	120.6
Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,611,312.62	(211,312.62)	108.8
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,274,000.00</b>	<b>18,273,977.61</b>	<b>22.39</b>	100.0
Бичиг хэрэг	2,710,400.00	2,744,700.00	(34,300.00)	101.3
Тээвэр, шатахуун	950,000.00	950,000.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,889,600.00	1,862,668.61	1,026,931.39	64.5
Ном, хэвлэл	300,000.00	731,800.00	(431,800.00)	243.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,380,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,044,000.00	10,604,809.00	(560,809.00)	105.6
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>67,000,000.00</b>	<b>66,999,190.00</b>	<b>810.00</b>	100.0
Багаж, техник, хэрэгсэл	35,000,000.00	34,999,190.00	810.00	100.0
Урсгал засвар	32,000,000.00	32,000,000.00	0.00	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>0.00</b>	100.0
Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>124,050,000.00</b>	<b>124,049,197.00</b>	<b>803.00</b>	100.0

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,326,000.00	120,325,360.00	640.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00	0.00	100.0
Газрын төлбөр	1,744,000.00	1,743,837.00	163.00	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,100,000.00</b>	<b>4,094,300.00</b>	<b>5,700.00</b>	99.9
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,100,000.00</b>	<b>4,094,300.00</b>	<b>5,700.00</b>	99.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,100,000.00	4,094,300.00	<b>5,700.00</b>	99.9
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,512,097,000.00</b>	<b>1,512,083,475.54</b>	(13,524.46)	100.0
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,493,597,000.00</b>	<b>1,493,590,659.54</b>	<b>6,340.46</b>	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,493,597,000.00	1,493,590,659.54	6,340.46	100.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>18,500,000.00</b>	<b>18,492,816.00</b>	<b>7,184.00</b>	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,500,000.00	18,492,816.00	7,184.00	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>144</b>	<b>127</b>	<b>17</b>	88.2
Удирдах ажилтан	1	1	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	121	104	17	86.0
Үйлчлэх ажилтан	22	22	0	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.0</b>	<b>239,884,238.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.0</b>	<b>239,884,238.00</b>
Бараа, үйлчилгээний зардал	0.0	239,866,311.85
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>0.0</b>	<b>239,866,311.85</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	239,866,311.85
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.0</b>	<b>17,926.15</b>
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.0</b>	<b>17,926.15</b>
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	17,926.15
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.0</b>	<b>239,884,238.00</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.0</b>	<b>17,828.0</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	17,828.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	<b>239,866,410.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчийн бус этгээдээс авсан хандив, тусламж	0.0	12,642,410.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	227,224,000.00

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Физик, технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020.02.25			САГ-2020/157/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Физик, технологийн хүрээлэн		Мянган төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Бараа материалын тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Алтайсайхан
Зарим ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд код, чанар, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тусгаагүй, эзэмшигчээр гарын үсэг зуруулаагүй	17,100.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Алтайсайхан
<b>Дүн</b>	<b>17,100.6</b>			





